



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 20 өдөр

Дугаар A/78

Модот

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.3, 19.2.4, 19.3.3, 19.3.4, дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2, 20.1.3, 20.1.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Нугаар багийн нутаг "Хавчир ганга" нэртэй газар нутаглаж байгаа малчин Д.Ариунболдынд УМЭАЦТЛ-ийн 2025 оны 06 сарын 21-ний өдрийн 25-3012 дугаартай шинжилгээний дүнгээр малын гоц халдварт Хонины цэцэг өвчин оношлогдож 2025 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн А/73 дугаар захирамжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласны үр дүнд өвчлөл илрээгүй тул хорио цээрийн дэглэмийг бууруулж 2025 оны 07 дугаар сарын 20-ний өдрөөс хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2.Голомтын бүсэд байгаа малчин Д.Ариунболдын суурьт ариутгал халдваргүйтгэлийг чанартай хийж гүйцэтгэхийг "Дэрст хайрхан" ХХК-ны мал эмнэлгийн нэгжид үүрэг болгосугай.

3.Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу малын эмч мэргэжилтэнд мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, Хязгаарлалтын дэглэм тогтоосон малын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, шаардагдах халдваргүйтгэлийн бодис, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн Хяналтын улсын байцаагч (П.Ганчимэг)-т үүрэг болгосугай

4.Сэжигтэй хамгаалалтын бүсийн өрхүүдэд халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийн талаар малчид, ард иргэдэд, ухуулга сурталчилгаа хүргэх, сэжигтэй болон хамгаалалтын бүсэд айл өрх нутаглуулахгүй байхыг Нугаар багийн засаг дарга Б.Чулуунцэцэгт, хязгаарлалтын дэглэмийн үед томилогдон ажиллаж байгаа ажилтан албан хаагчдад халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөр аюулгүй байдал, хүн малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэн ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Б.Хангай)-д даалгасугай

5.Хязгаарлалтын дэглэмийн үед гарах зардлыг гамшгийн эрсдэлийн сангаас зарцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Ганзориг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ